



## НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/441

Улаанбаатар хот

### Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн талбайн хэмжээ, байршил, оноосон нэр өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 32.7, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.1, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Газрын харилцаа геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам", Нийслэлийн Засаг даргын 2020 оны Б/91 дүгээр захирамж, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 10/09 дүгээр тогтоол, дүүргийн "Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл"-ийн 2021 оны 09 дугаар сарын 29-ний өдрийн хурлын дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн талбайн хэмжээ, байршил, оноосон нэр өөрчлөх тухай ирүүлсэн 7 (долоо) иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад заасны дагуу өөрчилсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан Дүүргийн Засаг даргын 2019 оны А/398 дугаар захирамжийн иргэн Ч.Жигжидсүрэн, Дүүргийн Засаг даргын 2018 оны А/646 иргэн Б.Эрдэнэбилэг, Дүүргийн Засаг даргын 2019 оны А/478 дугаар захирамжийн иргэн Ц.Бямбацэрэн, Дүүргийн Засаг даргын 2017 оны А/58 дугаар захирамжийн Мэргэн хангал ХХК, Дүүргийн Засаг даргын 2017 оны А/58 дугаар захирамжийн Мэргэн хангал ХХК, Дүүргийн Засаг даргын 2021 оны А/294 дүгээр захирамжийн иргэн Б.Эрдэнэжаргал, Дүүргийн Засаг даргын 2020 оны А/395 дугаар захирамжийн иргэн С.Ариунзаяа нарт холбогдох газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, хуулийн этгээдтэй холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гэрээ байгуулж, газрын улсын бүртгэлд бүртгэх, гэрчилгээ олгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Д.Энхтөр)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЬЯАБААТАР

Баянгол дүүргийн Засаг даргын  
2021 оны .10 дүгээр сарын .10 ны өдрийн  
Ардудугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ТАЛБAYН ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ, ХАЯГ,  
ОНООСОН НЭР ӨӨРЧЛӨХ, ХАМТРАН ЭЗЭМШИГЧ ХАСАХ, НЭМЭХ ТУХАЙ

Д/д	Газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Регистрийн дугаар	Газрын байршил /хороо/	Зориулалт	Хэмжээ /м2/	Хугацаа	Эдэлбэрийн хэлбэр Өмнөх эзэмшигч, зориулалт, талбайн хэмжээ, байршил, нэр	Өмнөх шийдвэр	Нэгж талбарын дугаар
1	Партизан овогтой Чимэдбалжирын Жигжидсүрэн	ЧМ62011470	6-р хороо 10-р хороолол-2/16081/	Амины орон сууц /2205/	264	15	12 3 Эзэмшүүлэх	2019.09.08 А/398 Шүүхийн шийдвэрийн дагуу	1680110029
2	Хиад боржигон овогтой Бямбажавын Эрдэнэбилэг	ЧТ64121419	15-р хороо, 4-р хороолол-3 /16062/	Үйлчилгээ	63.3 м2	15	60 Эзэмшүүлэх	2018 оны А/646	168010007.00
3	Тангууд овогтой Цэвээндоржийн Бямбацэрэн	ДБ76110811	20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс-2 /16101/	Худалдаа үйлчилгээ	999	15	80 0 Эзэмшүүлэх	2019 оны А/478	1681810010
4	Мэргэн хангал ХХК	5096794	20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс-4 /16103/	Аж ахуй	502	15	99 92 Эзэмшүүлэх	2017 оны А/58	1601900069

5	Мэргэн хангал ХХК	5096794	20-р хороо, Үйлдвэрийн н баруун бүс-4 /16103/	Аж ахуй	9490	15	Эзэмшүүлэх	2017 оны А/58	1601900069
6	Дэлгэр овогтой Батхуягийн Эрдэнэжаргал	ПЭ8310171 5	20-р хороо, Үйлдвэрийн н баруун бүс-1 /16103/	Аж ахуй	543	15	Эзэмшүүлэх	2021 оны А/294	1681600435
7	Олхон овогтой Сосорын Ариунзаяа	ЧВ75082500	20-р хороо, Үйлдвэрийн н баруун бүс-1 /16100/	Авто засвар, үйлчилгээ	424	15	Эзэмшүүлэх	2020 оны А/395	1681610046